



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГЛОБАЛЬ САНГИЙН ДЭМЖЛЭГТЭЙ ДОХ, СҮРЬЕЭГИЙН ТӨСЛИЙН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/273/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитор: Э.Энхбаатар
Утас: 261628 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Лидер экаунт аудит" ХХК-
ийн захирал П.Шаравхорол
Утас: 88112654 Цахим хаяг: leaderaudit.20@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХӨСҮТ	Халдварт судлалын үндэсний төв
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГЛОБАЛЬ САНГИЙН ДЭМЖЛЭГТЭЙ
ДОХ, СҮРЬЕЭГИЙН ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Н.ЦОГЗОЛМАА
ТАНАА

2022.02.24 № 07/346
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	3,414,622,944.31	11,758,291,407.27
31	МӨНГӨН БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	1,076,345,925.20	2,707,369,671.70
33	АВЛАГА	2,333,092,522.11	3,097,040,273.15
3305	Бусад авлага	2,333,092,522.11	3,097,040,273.15
330501	Байгууллагаас авах авлага	2,333,092,522.11	3,097,040,273.15
34	УРЬДЧИЛГАА	5,184,497.00	585,527,147.53
3406	Урьдчилж төлсөн зардал	497.00	575,685,147.53
3407	Урьдчилгаа тооцоо	5,184,000.00	9,842,000.00
340704	Томилолтын урьдчилгаа	5,184,000.00	9,842,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	-	5,368,354,314.89
3501	Түүхий эд материал	-	5,317,670,714.89
350102	Эм, боох материал	-	5,317,670,714.89
3504	Хангамжийн материал	-	50,683,600.00
350407	Бусад хангамжийн материал	-	50,683,600.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	6,123,215.65	25,150,186.15
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,123,215.65	25,150,186.15
3902	Биет хөрөнгө	6,123,215.65	18,693,519.52
390202	Авто тээврийн хэрэгсэл	-	117,814,396.72
39020201	Хуримтлагдсан элэгдэл	-	(117,814,396.72)
390203	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,849,445.73	65,169,592.27
39020301	Хуримтлагдсан элэгдэл	(19,504,144.65)	(56,230,462.29)
390204	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,577,354.46	26,017,358.68
39020401	Хуримтлагдсан элэгдэл	(1,799,439.89)	(16,262,969.14)
3903	Биет бус хөрөнгө	-	6,456,666.63
390301	Программ хангамж	-	20,320,000.00
39030101	Хуримтлагдсан элэгдэл	-	(13,863,333.37)
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,420,746,159.96	11,783,441,593.42
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,105,288,664.33	2,723,545,517.58
4101	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,105,288,664.33	2,723,545,517.58
4131	Өглөг	1,105,288,664.33	2,723,545,517.58
410306	Бусад өглөг	20,088,483.39	16,245,837.93
4140	Урьдчилж орсон орлого	1,085,200,180.94	2,707,299,679.65
410404	Бусад урьдчилж орсон орлого	1,085,200,180.94	2,707,299,679.65
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,315,457,495.63	9,059,896,075.84
51	Засгийн газрын хувь оролцоо	-	-
5102	Хуримтлагдсан үр дүн	2,315,457,495.63	9,059,896,075.84
510201	Өмнөх үеийн үр дүн	2,315,457,495.63	1,854,176,667.20
510202	Тайлант үеийн үр дүн	-	7,205,719,408.64
VI	НИЙТ ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,420,746,159.96	11,783,441,593.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,754,454,698.88	26,200,470,009.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,326,805,535.62	26,200,470,009.42
120	Нийтлэг татварын бус орлого	4,392,345,609.71	11,109,722,467.69
1200043	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	4,386,732,399.71	9,577,948,110.27
1200044	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,613,210.00	1,531,774,357.42
122	Тусламжийн орлого	4,934,459,925.91	15,090,747,541.73
122002	Хандив тусламж /гадаад/	4,934,459,925.91	15,090,747,541.73
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	427,649,163.26	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	427,649,163.26	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	427,649,163.26	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	10,513,436,983.70	18,995,794,788.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,513,436,983.70	18,995,794,788.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,085,787,820.44	17,464,090,423.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	828,481,369.17	2,549,032,035.95
210101	Үндсэн цалин	828,481,369.17	2,478,216,898.33
210104	Урамшуулал	-	70,815,137.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,592,079.87	120,506,185.10
210201	Тэтгэврийн даатгал	20,592,079.87	120,506,185.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,728,252.73	313,736,569.50
210301	Гэрэл, цахилгаан	2,264,675.88	-
210303	Цэвэр, бохир ус	4,071,741.23	27,242.50
210304	Байрны түрээс	115,391,835.62	313,709,327.00
2104	Хангамж, бараа материалын зардал	312,657,745.22	426,650,474.75
210401	Бичиг хэрэг	8,770,663.61	4,554,700.00
210402	Тээвэр, шатахуун	23,013,791.00	2,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,439,851.61	8,962,418.84
210404	Ном, хэвлэл	249,812,909.09	290,330,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,620,529.91	120,203,055.91
2105	Нормативт зардал	6,524,412,807.62	9,973,499,240.86
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,315,614,607.62	9,142,616,465.86
210502	Хоол, хүнс	208,798,200.00	830,882,775.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,652,760.00	11,395,760.00
210601	Багаж, техник хэрэгсэл	-	11,395,760.00
210604	Урсгал засвар	40,652,760.00	-
2107	Томилолт, зочны зардал	176,724,112.00	127,360,996.19
210702	Дотоод албан томилолт	174,614,112.00	127,360,996.19
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,110,000.00	-

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	680,414,699.27	823,284,803.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	653,571,075.27	791,281,553.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	30,724,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	16,843,624.00	1,272,750.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	6,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,380,123,994.56	3,118,624,357.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	719,400,739.36	1,824,990,000.60
210902	Сургалт семинарын зардал	653,775,879.91	1,278,984,027.27
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,947,375.29	14,650,330.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	427,649,163.26	1,531,704,365.37
213101	Засгийн газрын урсгал шилжүүлэг	427,649,163.26	1,531,704,365.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(758,982,284.82)	7,204,675,220.80
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	141,960,235.49	645,707.68
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз	141,960,235.49	645,707.68
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	5,613,210.00	(398,480.16)
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус гарз	-	(398,480.16)
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	5,613,210.00	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI)=(IV-V)	136,347,025.49	1,044,187.84
7	НИЙТ ҮР ДҮН	(622,635,259.33)	7,205,719,408.64

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	5,472,972,496.54	5,472,972,496.54
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(2,534,879,741.58)	(2,534,879,741.58)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	2,938,092,754.96	2,938,092,754.96
4	Тайлант үеийн үр дүн	-	(622,635,259.33)	(622,635,259.33)
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	2,315,457,495.63	2,315,457,495.63
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(461,280,828.43)	(461,280,828.43)
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	1,854,176,667.20	1,854,176,667.20
8	Тайлант үеийн үр дүн	-	7,205,719,408.64	7,205,719,408.64
9	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	9,059,896,075.84	9,059,896,075.84

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,169,305,640.50	11,221,158,650.66
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	69,992.05
110	Орлогын албан татвар	-	69,992.05
1100	Хувь хүний орлогын албан татвар	-	69,992.05
110002	Үйл ажиллагааны орлого	-	69,992.05
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,169,305,640.50	10,847,578,253.96
120	Нийтлэг татварын бус орлого	4,169,305,640.50	10,847,578,253.96
120002	Хүүгийн орлого	2,624,042.62	-
1200043	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	4,166,681,597.88	10,847,578,253.96
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	373,510,404.65
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	373,510,404.65
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	373,510,404.65
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,309,501,667.65	9,554,028,700.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,309,501,667.65	9,554,028,700.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,309,501,667.65	9,554,028,700.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	828,627,419.17	2,641,294,685.10
210101	Үндсэн цалин	828,627,419.17	2,566,584,488.10
210104	Урамшуулал		74,710,197.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,592,079.87	132,222,069.10
210201	Тэтгэврийн даатгал	20,592,079.87	132,222,069.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,221,889.11	316,956,530.50
21301	Гэрэл, цахилгаан	2,264,675.88	-
210303	Цэвэр, бохир ус	4,071,741.23	27,242.50
210304	Байрны түрээс	115,885,472.00	316,929,288.00
2104	Хангамж, бараа материалын зардал	273,849,195.29	357,949,066.84
210401	Бичиг хэрэг	6,720,309.07	4,554,700.00
210402	Тээвэр, шатахуун	27,924,363.73	2,820,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,901,651.61	8,318,418.84
210404	Ном, хэвлэл	206,722,000.00	224,746,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,580,870.88	117,509,148.00
2105	Нормативт зардал	908,433,100.00	1,018,471,573.43
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	705,371,100.00	187,001,173.43
210502	Хоол, хүнс	203,062,000.00	831,470,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,652,760.00	219,314,913.27
210601	Багаж техник, хэрэгсэл	-	80,263,380.00
210604	Урсгал засвар	40,652,760.00	139,051,533.27
2107	Томилолт, зочны зардал	221,439,935.00	158,761,635.00
210702	Дотоод албан томилолт	219,329,935.00	158,761,635.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,110,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	708,091,608.32	778,807,503.50

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	668,587,415.36	726,508,888.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	50,724,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	16,843,624.00	1,272,750.00
210807	Газрын төлбөр	12,307,745.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	352,823.96	301,865.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,185,593,680.89	3,930,250,723.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	709,983,434.98	2,794,935,434.18
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	475,610,245.91	1,135,315,289.27
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(140,196,027.15)	1,667,129,950.47
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	507,000.00	15,759,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	507,000.00	15,759,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	507,000.00	15,759,000.00
225001	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	15,759,000.00
2260	Гадаад эх үүсвэрээр	507,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-507,000.00	(15,759,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	65,096,607.81	(20,347,203.97)
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз	65,096,607.81	-
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус гарз	-	20,347,203.97
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(75,099,419.34)	1,631,023,746.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,151,445,344.54	1,076,345,925.20
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,076,345,925.20	2,707,369,671.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,951,708,279.30	24,660,535,241.92	708,826,962.62	103.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,951,708,279.30	24,660,535,241.92	708,826,962.62	103.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,951,708,279.30	24,644,776,241.92	693,067,962.62	102.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,712,497,310.62	2,641,294,685.10	-71,202,625.52	97.4
210101	Үндсэн цалин	2,624,306,634.96	2,566,584,488.10	-57,722,146.86	97.8
210104	Урамшуулал	88,190,675.66	74,710,197.00	-13,480,478.66	84.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	150,000,000.00	132,222,069.10	-17,777,930.90	88.1
210201	Тэтгэврийн даатгал	150,000,000.00	132,222,069.10	-17,777,930.90	88.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	320,030,000.00	316,956,530.50	-3,073,469.50	99.0
210303	Цэвэр, бохир ус	30,000.00	27,242.50	-2,757.50	90.8
210304	Байрны түрээс	320,000,000.00	316,929,288.00	-3,070,712.00	99.0
2104	Хангамж, бараа материалын зардал	621,219,645.60	357,949,066.84	-263,270,578.76	57.6
210401	Бичиг хэрэг	4,600,000.00	4,554,700.00	-45,300.00	99.0
210402	Тээвэр, шатахуун	2,800,000.00	2,820,000.00	20,000.00	100.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,500,000.00	8,318,418.84	-181,581.16	97.9
210404	Ном, хэвлэл	488,319,645.60	224,746,800.00	-263,572,845.60	46.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	117,000,000.00	117,509,148.00	509,148.00	100.4
2105	Нормативт зардал	13,104,242,488.10	16,109,218,715.16	3,004,976,227.06	122.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,269,754,856.10	15,277,748,715.16	3,007,993,859.06	124.5
210502	Хоол, хүнс	834,487,632.00	831,470,000.00	-3,017,632.00	99.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,287,245,376.96	219,314,913.27	-1,067,930,463.69	17.0
210601	Багаж техник хэрэгсэл	877,570,176.96	80,263,380.00	-797,306,796.96	9.1
210604	Урсгал засвар	409,675,200.00	139,051,533.27	-270,623,666.73	33.9
2107	Томилолт, зочны зардал	160,000,000.00	158,761,635.00	-1,238,365.00	99.2
210702	Дотоод албан томилолт	160,000,000.00	158,761,635.00	-1,238,365.00	99.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,596,473,458.02	4,709,058,626.95	-887,414,831.07	84.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	5,596,473,458.02	4,709,058,626.95	-887,414,831.07	84.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		15,759,000.00	15,759,000.00	
2210	Дотоод эх үүсвэрээр /биет бус хөрөнгө, хураамж/		15,759,000.00	15,759,000.00	
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		26,291,558,988.42	26,291,558,988.42	
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		10,847,578,253.96	10,847,578,253.96	
350004	Гадаад эх үүсвэрээс санхүүжих		10,847,578,253.96	10,847,578,253.96	
36	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих		15,090,747,541.73	15,090,747,541.73	
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих		15,090,747,541.73	15,090,747,541.73	

37	Бусад эх үүсвэр		353,233,192.73	353,233,192.73	
370001	Бусад эх үүсвэр		69,992.05	69,992.05	
370002	ДОХ /MNG-Н-МОН/-ын төслийн үлдэгдлийг данс хааж Сүрьеэгийн төсөлд шилжүүлсэн		373,510,404.65	373,510,404.65	
370002	Тохируулга		-20,347,203.97	-20,347,203.97	
12000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,076,345,925.20	1,076,345,925.20	
12000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,707,369,671.70	2,707,369,671.70	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	17	17		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	13	13		
620003	Үйлчлэх ажилтан	3	3		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад мөнгөн хөрөнгийн зарцуулалт, анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулах, худалдан авалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Лидер экаунт аудит ХХК-ийн ахлах аудитор Ш.Уянга, аудитор Ч.Отгонцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал П.Шаравхорол хэрэгжүүлсэн.

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Лидер экаунт аудит ХХК-д 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 22/20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Глобаль сангийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа хөтөлбөрийн зорилго нь ХДХВ-ийн тархалт, ДОХ-той холбоотой нас баралтыг бууруулах, хүн төвтэй эрүүл мэндийн цогц үйлчилгээ үзүүлж, сүрьеэгийн тохиолдол илрүүлэлтийг нэмэгдүүлж оношилгоо, эмчилгээний шинэлэг аргуудыг нэвтрүүлж, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэхэд чиглэгдэж байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2021-2023 онд ХДХВ-ийн халдварын илрүүлэлтийг 70 хувьд хүргэх, сүрьеэгийн бүх тохиолдлын илрүүлэлтийн түвшинг 55 хувь хүртэл нэмэгдүүлэх, 2021 оноос хиймэл оюун ухааны технологийг сүрьеэгийн оношилгоонд нэвтрүүлэх, эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөнүүдэд явуулын тусламж үйлчилгээг нэвтрүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн нэгжийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;
- ХДХВ-ийн халдвар илрүүлэх оношилгоо, үйлчилгээ;
- ХДХВ, Сүрьеэгийн хавсарсан халдварын тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх хөтөлбөр;
- Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөц, нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудын чадавхжуулах хөтөлбөр;
- Эмийн тэсвэртэй сүрьеэгийн тусламж үйлчилгээ;
- Олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, судалгаа шинжилгээ, байгууллагын чадавхыг бэхжүүлэх, манлайллыг хөгжүүлэх;
- Эрүүл мэндийн менежментийн мэдээллийн систем, хяналт-шинжилгээ, үнэлгээ;
- Хөтөлбөрийн менежмент;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаал “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус төсөл нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй боловч Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, Засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг мөрдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 10,513,436.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 210,268.7 мянган төгрөгөөр,

гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 168,215.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянан үзэхэд Глобаль сангаас 2021-2023 онд хэрэгжүүлэх төслийн хүрээнд ДОХ, Сүрьеэгийн төслийн үйл ажиллагааг нэгтгэж, төслийн санхүүжилтийг олгож байгаатай холбогдон 2021 оны төслийн нийт зардал өмнөх оноос 44.6 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа тул гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 18,995,794.8 мянган төгрөгөөс 2 хувь буюу 379,915.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг материаллаг байдлын 80 хувиар буюу 303,932.7 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,362,695.5 мянган төгрөгөөр буюу 3.4 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,076,345.9	2,707,369.7	1,631,023.8
Авлага	2,333,092.5	3,097,040.3	763,947.8
Урьдчилж гарсан тооцоо	5,184.5	585,527.1	580,342.6
Бараа материал	-	5,368,354.3	5,368,354.3
Үндсэн хөрөнгө	6,123.2	25,150.2	19,027.0
Нийт хөрөнгө	3,420,746.1	11,783,441.6	8,362,695.5
Өр төлбөр	1,105,288.7	2,723,545.5	1,618,256.8
Хуримтлагдсан үр дүн	2,315,457.4	9,059,896.1	6,744,438.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,420,746.1	11,783,441.6	8,362,695.5

Дансны үлдэгдэлд дараах материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,631,023.8 мянган төгрөгөөр өссөн нь Глобаль сангаас ДОХ, Сүрьеэгийн төслийн санхүүжилтэд 10,847,578.2 мянган төгрөг, ДОХ-ын өмнөх төслийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 373,510.4 мянган төгрөгийг татан нэгтгүүлсэн;
- Авлага дансны үлдэгдэл 3,097,040.3 мянган төгрөг болж, 763,947.8 мянган төгрөгөөр өссөн нь гадаад ханган нийлүүлэгч байгууллагуудад захиалсан эм, эмнэлгийн бүтээгдэхүүн, эмнэлгийн тоног төхөөрөмжийн нийлүүлэлтээс шалтгаалжээ. Нийт авлагын 2,513,869.3 мянган төгрөг нь гадаад ханган нийлүүлэгч байгууллагаас авах авлага, 579,447.1 мянган төгрөг нь дотоодын байгууллагаас авах авлага;
- Урьдчилж гарсан зардал 585,527.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь салбар хүлээн авагч байгууллагуудад олгосон санхүүжилтийн үлдэгдэл;
- Бараа материалын үлдэгдэл 5,368,354.3 мянган төгрөг байгаа нь дотоодын байгууллагуудаас худалдан авсан бараа материал 1,253,292.8 мянган төгрөг, хөрөнгийн санхүүжилтээр 10,905,036.9 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, нийт 12,158,329.7 мянган төгрөгийн бараа материалын орлого авснаас Эрүүл мэндийн сайдын тушаалаар 5,679,892.7 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан, 813,506.0

мянган төгрөгийн хүнсний материалыг эмзэг бүлгийн иргэдэд олгож, 296,576.7 мянган төгрөгийн аж ахуйн материалыг зарцуулсан;

- Өр төлбөр дансны үлдэгдэл нь гадаадын ханган нийлүүлэгч байгууллагаас урьдчилан нийлүүлсэн эм, эмнэлгийн бүтээгдэхүүний тооцоо 16,245.8 мянган төгрөг, салбар хүлээн авагч байгууллагуудын санхүүжилтийн үлдэгдэл 575,685.1 мянган төгрөг байна.

ДОХ, Сүрьеэгийн төслийн үйл ажиллагааны нийт орлого 26,200,470.0 мянган төгрөг үүнээс үйл ажиллагааны санхүүжилтийн орлого 9,577,948.1 мянган, гадаад хандив тусламжийн орлого 15,090,747.5 мянган төгрөг байна. Үйл ажиллагааны зардалд нийт 18,995,794.7 мянган төгрөгийг зарцуулсны дотор цалин, шимтгэлийн зардалд 2,669,538.2 мянган, бараа үйлчилгээний зардалд 10,852,643.0 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 823,284.8 мянган, бусад зардалд 3,118,624.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Глобаль сан нь 2021-2023 онд “Монгол Улсад ХДХВ/ДОХ, Сүрьеэгээс сэргийлэх, эмчилгээ, тусламж үйлчилгээ үзүүлэх үндэсний хөтөлбөрийг бэхжүүлэх” төслийн хүрээнд 13,344.3 мянган ам.доллар буюу 36,349,873.2 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгохоор хамтын ажиллагааны зарчмын гэрээг байгуулсан байна.

Тайлант онд Глобаль сангаас ДОХ, Сүрьеэгийн төслийн үйл ажиллагаанд зориулж 14,834,113.2 мянган төгрөг, Ковид 19 цар тахлын хариу арга хэмжээнд зориулж С19RM нэмэлт санхүүжилтэд 9,117,595.3 мянган төгрөг, нийт 23,951,708.5 мянган төгрөгийн мөнгөн болон хөрөнгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Глобаль сангаас 2021 онд ДОХ, Сүрьеэгийн төслийн үйл ажиллагаанд зориулж 10,847,578.3 мянган төгрөгийн санхүүжилт, 15,090,747.5 мянган төгрөгийн хөрөнгөөрх санхүүжилт, нийт 25,938,325.8 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байна.

Гүйцэтгэлээр нийт 24,660,535.2 мянган төгрөгийг зарцуулж, төлөвлөсөн хэмжээнээс 708,826.9 мянган төгрөгөөр хэтэрсэн нь Ковид 19 цар тахлын үед эрсдэлд бүлгийн хүн амд олгосон эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл болон хүнсний багцын зардалд 16,109,218.7 мянган төгрөг зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Глобаль сангаас Ковид 19 хариу арга хэмжээ, бэлэн байдлыг хангах чиглэлээр 2021-2023 оны төсөлд нэмэлтээр 4,170.5 мянган ам доллар буюу 11,078,304.7 мянган төгрөгийг олгохоор төлөвлөснөөс 2021 онд 9,117,595.2 мянган төгрөгийг олгосон байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улс, Глобаль сангийн Хамтын ажиллагааны зарчмын тухай гэрээний дагуу 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх MNG-C-MOH хөтөлбөрийн хугацаанд 2,724.00 төгрөгийн ханшийг баримтлахаар зааж өгснийг төслийн бүртгэлд баримталж байна.

Төслийн үйл ажиллагаа нь ДОХ/ХДХВ-ын халдвар илрүүлэх, урьдчилан сэргийлэлт, эмчилгээ тусламж үйлчилгээний 9 хөтөлбөр, сүрьеэгийн эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэлт, лабораторын тогтолцоо ба мэдээллийн системийн менежментийн 8 хөтөлбөр хэрэгжиж байна.

ДОХ-ын хөтөлбөрийг 3 салбар хүлээн авагч байгууллагаар, сүрьеэгийн хөтөлбөрийг 7 салбар хүлээн авагч байгууллагаар дамжуулан хэрэгжүүлж байна.

3.8 Аудитын гол асуудал

Салбар хүлээн авагч байгууллагуудад олгосон үйл ажиллагааны болон нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг шалгаж үзэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөөгүй зэрэг нийтлэг алдаа, зөрчил байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна.

3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Глобаль сангийн ДОХ, Сүрьеэгийн төсөл нь нийт 8,390,567.7 мянган төгрөгийн 101 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод, холбогдох шийдвэрүүдийн хамт байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо ТББ Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хөтлөгдөх анхан шатны бүртгэлийн журналыг боловсруулж, хэвлүүлэх 60,000,000.00 төгрөгийн ажлын гэрээг шууд байгуулсан. Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг ТББ иргэд, өсвөр үеийнхэнд чиглэсэн сүрьеэ өвчний талаар үнэн зөв мэдлэг олгох интерактив сургалтын материал боловсруулж, сошиалаар түгээх нийт 80,990,000.00 төгрөгийн ажлын тендер зарлалгүй хэд хэдэн багцад хуваан гэрээ хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсвэл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”, мөн

хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 1.7(в) “худалдан авах ажиллагааг цахимаар /tender.gov.mn/ зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд оруулж нийтэд мэдээлж байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

3.10 ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Завсрын аудитаар нийт 62,330.0 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илрүүлж, 2 зөвлөмж өгч жилийн эцсийн аудитаар дахин хянахад дээрх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 75,905.0 мянган төгрөгийн 6 зөрчлөөс шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 2 албан шаардлага, 75,905.0 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	-	2	-	-	-	100.0
Зөвлөмж	4	75,905.00	4	75,905.00	-	-	100.0
Нийт дүн	6	75,905.00	6	75,905.00	-	-	100.0

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Глобаль сангийн буцалтгүй тусламжаар Халдвар судлалын үндэсний төв болон аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад олгосон эмнэлгийн тоног төхөөрөмжийг бүртгэл тайланд тусгасан эсэх, тайлант оны сүүлийн хагаст хүлээн авсан эм, эмнэлгийн хэрэгслээс хуваарилагдаагүй 5,317,670.7 мянган төгрөгийн үлдэгдлийг тушаал шийдвэрийн дагуу хуваарилсан эсэхийг тулган шалгах.

Санхүүгийн тайланд салбар хүлээн авагч байгууллагуудад олгосон санхүүжилтийн үлдэгдэл 575,685.1 мянган төгрөгийг салбар хүлээн авагчдын мөнгөн урьдчилгааны тайлан, хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны тайлантай харьцуулах, үндсэн хүлээн авагчийн хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагааг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 86,683.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,845.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 32,201.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 49,647.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Төлбөрийн акт

Сүрьеэгийн эмийг чанарын хяналтын шинжилгээнд хамруулахад зориулан ХӨСҮТ-ийн Тандалт судалгааны албанаас Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт 4,845.0 мянган төгрөгийг шилжүүлэхдээ данс андуурч шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Данс андуурч шилжүүлсэн сүрьеэгийн эмийн шинжилгээний төлбөр 4,845.0 мянган төгрөгийг буцааж авах, төлбөрийн акт тогтоох.

4.2 Албан шаардлага

1. Эрүүл сүрьеэгүй ирээдүйн төлөө ТББ нь Миний бэлэг продюсинг ХХК-д гарын авлага боловсруулах, хэвлэл мэдээллийн ажилтнуудад сургалт зохион байгуулахад 5,143.8 мянган төгрөг, Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоо ТББ нь Монжаргалант ХХК-д түрээсийн төлбөрт 5,330.0 мянган төгрөг шилжүүлсэн, ХӨСҮТ-ийн Тандалт судалгааны алба нь Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоонд сургалтын болон сүрьеэгийн шинжилгээнд сорьц илгээх болон сүрьеэ өвчний тохиолдлын илрүүлэлтэд зориулж 4,080.0 мянган төгрөг, Залуус эрүүл мэнд ТББ нь Түвшин хангайн буян ХХК-иас 15,920.0 мянган төгрөгийн хүнсний багц худалдан авсан боловч төлбөрийн цахим баримт аваагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 6.5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын “тохиолдсон байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулан авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүр хянаж ажиллах албан шаардлага өгөх.

2. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Тандалт судалгааны алба нь Улаанбаатар смарт карт ХХК-иас автобусны картыг худалдан авч, 1,728.0 мянган төгрөгийн картын үлдэгдлийн тооцоо хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, санхүүгийн тайлагналын “тохиолдсон байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалыг хүлээн авсан, зарцуулсан, үлдэгдлийн тооцоог тухай бүр хийж байх албан шаардлага өгөх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тандалт судалгааны алба нь Би Си Ти ХХК-иас 21.087.0 мянган төгрөгийн үнэ бүхий камер, чихэвч худалдан авсан, Эрүүл сүрьеэгүй ирээдүйн төлөө ТББ нь Ковид-19 цар тахлын үед ДОХ, Сүрьеэ өвчний талаар урьдчилан сэргийлэх, ярилцлага, мэдээлэл телевизээр цацах, гарын авлага боловсруулах ажилд зориулан Энх-арслан ХХК-д нийт 18,560.0 мянган төгрөгийг олгосон баримтын бүрдэлгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 "Анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13.7 "Анхан шатны бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчиж, тохиолдсон байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэснийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт

Эрүүл сүрьеэгүй ирээдүйн төлөө ТББ нь өөр чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг Нью оптик ХХК-д шатахууны үнэнд 10,000.0 мянган төгрөгийг олгосон ч тус компанитай гэрээ байгуулаагүй, зарцуулалтын тайлангүй байна.

Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам"-ын 9.1.11 "төслийн хүрээнд бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэхээр сонгон шалгарсан этгээдтэй гэрээ байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах, дүгнэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэхээр сонгон шалгарсан этгээдтэй гэрээ байгуулж, биелэлтийг дүгнэж, бүртгэл хөтлөлтийг сайжруулж ажиллах, давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн Үүнээс							
					Албан шаардлага		Акт		Хариуцлага тооцох АШ		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар												
1	Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл	АХГ-2022/273/Н А-СТА-ТШЗ	Сүрьеэгийн эмийг чанарын хяналтын шинжилгээнд хамруулахад зориулан ХӨСҮТ-ийн Тандалт судалгааны албанаас Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт 4,845.0 мянган төгрөгийг шилжүүлэхдээ данс андуурч шилжүүлсэн, данс андуурч шилжүүлсэн мөнгийг буцаан олж аваагүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.	1	4,845.0	1	4,845.0				
2	Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл	АХГ-2022/273/Н А-СТА-ТШЗ	Эрүүл сүрьеэгүй ирээдүйн төлөө ТББ нь Миний бэлэг продюсинг ХХК-д гарын авлага боловсруулах, хэвлэл мэдээллийн ажилтнуудад сургалт зохион байгуулахад 5,143.8 мянган төгрөг, Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоо ТББ нь Монжаргалант ХХК-д түрээсийн төлбөрт 5,330.0 мянган төгрөг шилжүүлсэн, ХӨСҮТ-ийн Тандалт судалгааны алба нь ХХЭМБ-ын нэгдсэн холбоонд сургалтын болон сүрьеэгийн шинжилгээнд сорьц илгээх болон сүрьеэ өвчний тохиолдлын илрүүлэлтэд зориулж 4,080.0 мянган төгрөг, Залуус эрүүл мэнд ТББ нь Түвшин хангайн буян ХХК-аас 15,920.0 мянган төгрөгийн хүнсний багц худалдан авсан боловч төлбөрийн цахим баримт аваагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын 6.5 "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.	1	30,473.8			1	30,473.8		
3	Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл	АХГ-2022/273/Н А-СТА-ТШЗ	ХӨСҮТ-ийн Тандалт судалгааны алба нь Улаанбаатар смарт карт ХХК-аас автобусны картыг худалдан авч, 1,728.0 мянган төгрөгийн картын үлдэгдлийн тооцоо хийгээгүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", санхүүгийн	1	1,728.0			1	1,728.0		

				тайлагналын “тохиолдсон байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.									
4	Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл	АХГ-2022/273/Н А-СТА-ТШЗ	ХӨСҮТ-ийн Тандалт судалгааны алба нь Би Си Ти ХХК-аас 21.087.0 мянган төгрөгийн үнэ бүхий камер, чихэвч худалдан авсан, Эрүүл сүрьеэгүй ирээдүйн төлөө ТББ нь Ковид-19 цар тахлын үед ДОХ, Сүрьеэ өвчний талаар урьдчилан сэргийлэх, ярилцлага, мэдээлэл телевизээр цацах, гарын авлага боловсруулах ажилд зориулан Энх-арслан ХХК-д нийт 18,560.0 мянган төгрөгийг олгосон баримт дутуу байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 "Анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13.7 "Анхан шатны бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчиж, тохиолдсон байх ба эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.	1	39,647.0					1	39,647.0	
5	Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл	АХГ-2022/273/Н А-СТА-ТШЗ	Эрүүл сүрьеэгүй ирээдүйн төлөө ТББ нь өөр чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг Нью оптик ХХК-д шатахууны үнэнд 10,000.00 мянган төгрөгийг олгосон ч тус компанитай гэрээ байгуулаагүй, зарцуулалтын тайлангүй байна.	Засгийн газрын 2016 оны 176-р тогтоолоор батлагдсан журмын 9.1.11-д "төслийн хүрээнд бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэхээр сонгон шалгарсан этгээдтэй гэрээ байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах, дүгнэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөөгүй байна.	1	10,000.0					1	10,000.0	
Дүн					5	86,693.8	1	4,845.0	2	32,201.8	2	49,647.0	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар													
1	Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл	АХГ-2022/273/Н А-СТА-ТШЗ	Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг ТББ нь иргэд, өсвөр үеийнхэнд чиглэсэн сүрьеэ өвчний талаар үнэн зөв мэдлэг олгох интерактив сургалтын материал боловсруулж, сошиалаар түгээхэд 80,990.0 мянган төгрөг, Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо ТББ нь Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хөтөлөгдөх анхан шатны бүртгэлийн журналыг боловсруулж, хэвлүүлэхэд 60,000.0 мянган төгрөгийг зарцуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөөгүй байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсвэл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.	1	140,990.0				1	140,990.0		
Дүн					1	140,990.0				1	140,990.0		
Нийт дүн					6	227,683.8	1	4,845.0	3	173,191.8	2	49,647.0	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 52/40150054

Улаанбаатар хот

АХГ-2022/043/НА-СТН-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд данс андуурч шилжүүлсэн сүрьеэгийн эмийн шинжилгээний төлбөр 4,845,000.00 төгрөгийг буцаан аваагүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Данс андуурч шилжүүлсэн сүрьеэгийн эмийн шинжилгээний төлбөр 4,845,000.00 /дөрвөн сая найман зуун дөчин таван мянган/ төгрөгийг буцааж авч, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Төрийн сан банкна дахь 100900020408 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн нэгжийн зохицуулагч Н.Цогзолмаа, санхүүгийн ахлах мэргэжилтэн Б.Шинэтуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА

Ш.УЯНГА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 280/А150054
АХГ-2022/273/НА-СТА-ТЦБ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо ТББ Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хөтлөгдөх анхан шатны бүртгэлийн журналыг боловсруулж, хэвлүүлэх 60,000,000.00 төгрөгийн ажлын гэрээг шууд байгуулсан. Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг ТББ иргэд, өсвөр үеийнхэнд чиглэсэн сүрьеэ өвчний талаар үнэн зөв мэдлэг олгох интерактив сургалтын материал боловсруулж, сошиалаар түгээх нийт 80,990,000.00 төгрөгийн ажлын тендер зарлалгүй хэд хэдэн багцад хуваан гэрээ хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсвэл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 1.7(в) "худалдан авах ажиллагааг цахимаар /tender.gov.mn/ зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд оруулж нийтэд мэдээлж байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Глобал сангийн ДОХ, Сүрьеэгийн төслийн нэгжийн зохицуулагч Н.Цогзолмаа, санхүүгийн ахлах мэргэжилтэн Б.Шинэтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Ш.УЯНГА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban-Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-284.Docx

00108C0857



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 281/А0150054

Улаанбаатар хот

АХГ-2022/273/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд сургалт зохион байгуулахад 5,143,880,00 төгрөг, түрээсийн зардалд 5,330,000.00 төгрөг, сүрьеэгийн шинжилгээнд сорьц илгээх болон сүрьеэ өвчний тохиолдлын илрүүлэлтийн зардалд 4,080,000.00 төгрөг, хүнсний багц худалдан авахад 15,920,000.00 төгрөгийг тус тус шилжүүлсэн боловч төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын "тохиолдсон байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авалтын гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулан авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүр хянаж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. 2 Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Глобал сангийн ДОХ, Сүрьеэгийн төслийн нэгжийн зохицуулагч Н.Цогзолмаа, санхүүгийн ахлах мэргэжилтэн Б.Шинэтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Ш.УЯНГА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-704230

\\0.10.10.20\Bichtig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-285.Docx

0010800859



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 282/А150054
АХГ-2022/273/НА-СТА-ОУС

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Тандалт судалгааны алба нь Улаанбаатар смарт карт ХХК-аас автобусны картыг худалдан авч, 1,728,000.0 төгрөгийн картын үлдэгдлийн тооцоог хийгээгүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, санхүүгийн тайлагналын “тохиолдсон байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгийн орлого, зарлага, үлдэгдлийн тооцоог тухай бүр хийж, хяналт тавьж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Глобаль сангийн ДОХ, Сүрьеэгийн төслийн нэгжийн зохицуулагч Н.Цогзолмаа, санхүүгийн ахлах мэргэжилтэн Б.Шинэтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Ш.УЯНГА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-204230

\\10.10.20\Bichig_Kherig\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-287.Docx

0010800861

